

МХБХ-ны Зөвлөлийн
2019 оны 07 дугаар сарын
18-ны өдрийн №01 тоот
тогтоолоор батлав.



**МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ
ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

АГУУЛГА

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Тэмцээн зохион байгуулалт

Гурав. Футзалын тэмцээнүүд ба зэрэглэл

Дөрөв. Талбайн тэмцээнүүд ба зэрэглэл

Тав. Бүртгэл, шилжилт хөдөлгөөн

Зургаа. Техникийн зөвлөгөөн ба сугалаа

Долоо. Тоглолтын хувцас, хэрэглэл

Найм. Дүн гаргалт

Ес. Хугацаа

Арав. Тэмцээний үед мөрдөх журам

Арван нэг. Шагнал урамшуулал

Арван хоёр. Багийн менежер, дасгалжуулагч, багийн ахлагч, эмчийн эрх, үүрэг

Арван гурав. Хуудасны торгууль

Арван дөрөв. Эмч

Арван тав. Аюулгүй байдал, харуул хамгаалалт

Арван зургаа. Хэвлэл мэдээлэл, маркетинг

Арван долоо. Тэмцээн зохион байгуулах комисс

Арван найм. Бусад

НЭР, ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:

Дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1. FIFA/ОУХБХ – Олон Улсын хөлбөмбөгийн холбоо;
2. AFC/АХБХ – Азийн хөлбөмбөгийн холбоо;
3. МХБХ – Монголын хөлбөмбөгийн холбоо;
4. Тоглогчдын шилжилт хөдөлгөөний цонх – Тоглогчдын шилжилт хөдөлгөөнийг баталгаажуулах хугацаа;
5. Цонх хаагдах хугацаа – шилжилт хөдөлгөөний бүртгэл дуусах хугацаа;
6. ТЗБК – Тэмцээн зохион байгуулах комисс;
7. Техникийн зөвлөгөөн – Тэмцээнд оролцох багуудын албан хүмүүст зориулсан хурал;
8. Тоглолтын дүрэм – FIFA Laws of the Game/ FIFA Futsal Laws of the Game;
9. Match Commissioner – Тоглолтын зохион байгуулагч;
10. Шүүгчийн хэлтэс – МХБХ-ны бүтэц;
11. Тэмцээн зохион байгуулах хэлтэс – МХБХ-ны бүтэц;
12. ИТС – ОУХБХ-ны Тоглогчийн Шилжилт хөдөлгөөний гэрчилгээ;
13. Багийн албаны хүмүүс – Клуб, багийн эзэн, ахлах болон туслах дасгалжуулагч, эмч;
14. Албан ёсны бүртгэлтэй – Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авсан, МХБХ-ны тэмцээнд оролцох хүсэлтэй бөгөөд түүний гишүүн болох албан ёсны хүсэлт гаргасан клуб, баг;
15. FIFA Connect систем – ОУХБХ-ны тоглогчдын бүртгэлийн систем

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсад хөлбөмбөгийн спортыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгод нийцүүлэн нийтийн хөлбөмбөгөөс мэргэжлийн хөлбөмбөг хүртэлх бүх төрөл, ангиллын тэмцээнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэгдсэн стандартын дагуу системтэй, тогтвортой хөгжүүлэх бодлогын хүрээнд энэхүү журмыг боловсруулав.
- 1.2. Монголын Хөлбөмбөгийн Холбоо /цаашид "МХБХ" гэх/-ноос зохион байгуулах бүх тэмцээний зэрэглэл, хугацаа, багийн статус, насны ангилал зэрэг тухайн тэмцээнүүдтэй холбогдон гарах харилцааг энэхүү "Тэмцээн зохион байгуулах журам"-аар зохицуулна.
- 1.3. Тэмцээнийг МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс /цаашид "ТЗБХ" гэх/ нь, Олон Улсын хөлбөмбөгийн холбоо /FIFA/, Азийн хөлбөмбөгийн холбоо /AFC/, Монголын хөлбөмбөгийн холбоо /МХБХ/-ны дүрэм, журмуудыг болон бусад эрх зүйн бичиг баримтуудыг үндэслэн зохион байгуулна.

Хоёр. Тэмцээний зохион байгуулалт

- 2.1. МХБХ нь лиг болон улсын аваргын түвшинд бүх нас, ангиллын шигшээ болон урьдчилсан шатны тэмцээнүүдийг зохион явуулна. Тэмцээнд МХБХ-нд албан ёсны бүртгэлтэй, байнгын үйл ажиллагаатай клуб, баг, Орон нутгийн хөлбөмбөгийн холбооны шигшээ баг болон клуб хамрагдана.
- 2.2. МХБХ-ны тэмцээнийг талбай болон футзалын төрлөөр зохион байгуулна.
- 2.3. Клуб, баг нь МХБХ-ны тэмцээн зохион байгуулалттай холбогдох бүхий л дүрэм, журам, заавартай сайтар танилцаж, тэдгээр шаардлагуудыг зайлшгүй биелүүлсэн нөхцөлд тэмцээнд оролцох эрхтэй.
- 2.4. Клуб, баг нь МХБХ-ны "Тэмцээн зохион байгуулах журам"-ын бүртгэл ба мэдүүлэгтэй холбоотой шаардлагуудыг бүрэн хангаагүй тохиолдолд ТЗБХ тухайн клуб, багийг тэмцээнд оруулахгүй байх эрхтэй.
- 2.5. Орон нутгийн клубүүд нь тухайн Орон нутгийн хөлбөмбөгийн холбоонд харьяалагдана. Тэмцээнтэй холбогдолтой асуудлаар гагцхүү Орон нутгийн хөлбөмбөгийн холбоогоор дамжуулж МХБХ-той харилцана.
- 2.6. МХБХ-ноос зохион байгуулсан тэмцээний тоглолт бүрт шүүгчийн шийдвэр нь эцсийн шийдвэр байна.
- 2.7. Тэмцээний тоглолтод хамааралтай МХБХ-ны дүрэм, журамд тусгагдаагүй асуудлыг ТЗБХ бүрэн эрхийн хүрээнд эцэслэн шийдвэрлэнэ. ТЗБХ-ийн шийдвэр эцсийнх байна.
- 2.8. Шүүгч болон шүүлтэй холбогдсон үйл ажиллагааг Шүүгчийн хорооноос баталсан журмын дагуу зохицуулна. МХБХ-ны тэмцээнд Шүүгчийн хэлтсээс бэлтгэгдсэн, тангараг өргөсөн шүүгч нарыг томилно.
- 2.9. МХБХ-ны тэмцээн шүүх шүүгч нарыг Шүүгчийн хэлтсээс томилогдсон Хянагч шүүгч хянаж ажиллана.
- 2.10. МХБХ-ны тэмцээний Match Commissioner /Тоглолт зохион байгуулагч/-ийг ТЗБХ томилно.
- 2.11. Тоглолт зохион байгуулагч нь МХБХ-ны ТЗБХ-ийг төлөөлөх бүрэн эрхтэй.
- 2.12. Клуб, баг, орон нутгийн хөлбөмбөгийн холбоод МХБХ-нд жилийн гишүүнчлэлийн хураамж төлсөн тохиолдолд тэмцээнд оролцох эрхтэй.

Гурав. Футзалын тэмцээнүүд ба зэрэглэл

3.1. МХБХ-ноос дараах тэмцээнүүдийг футзалын ангиллаар зохион байгуулна. Үүнд:

3.1.1. Дээд зэрэглэл:

- 1) Футзалын Дээд Лиг
- 2) Футзалын МХБХ-ны Цом
- 3) Эмэгтэйчүүдийн Футзалын Лиг
- 4) Супер Цом

3.1.2. 1-р зэрэглэл:

- 1) Футзалын Нэгдүгээр Лиг
- 2) Футзалын Үндэсний Цом
- 3) Эмэгтэйчүүдийн ФУАШТ
- 4) Хөвгүүдийн U14, U16 Лиг
- 5) Залуучуудын U19 Лиг

3.1.3. 2-р зэрэглэл:

- 1) Футзалын УАШТ
- 2) Залуучуудын U19 ФУАШТ
- 3) Футзалын Үндэсний цом U16
- 4) Охидын U15 ФУАШТ
- 5) Охидын U11, U13 Футзалын Тэмцээн
- 6) Хөвгүүдийн U10, U12 Футзалын Тэмцээн
- 7) Хөвгүүдийн U14, U16 Футзалын Тэмцээн

3.1.4. 3-р зэрэглэл:

- 1) Ахмадын ФУАШТ
- 2) Фестиваль
- 3) Бусад тэмцээн

Дөрөв. Талбайн тэмцээнүүд ба зэрэглэл

4.1 МХБХ-ноос дараах тэмцээнүүдийг талбайн ангиллаар зохион байгуулна. Үүнд:

4.1.1. Дээд зэрэглэл:

- 1) Үндэсний “Дээд Лиг”
- 2) МХБХ-ны Цом
- 3) Супер Цом
- 4) Эмэгтэйчүүдийн Лиг

4.1.2. 1-р зэрэглэл:

- 1) МХБХ-ны “Нэгдүгээр Лиг”

- 2) Үндэсний Цом
- 3) Хөвгүүдийн U14, U16,
- 4) Залуучуудын U19 Лиг
- 5) Эмэгтэйчүүдийн УАШТ

4.1.3. 2-р зэрэглэл:

- 1) МХБХ-ны “Хоёрдугаар Лиг”
- 2) Охидын U15 УАШТ
- 3) Хөвгүүдийн U14, U16 УАШТ
- 4) Залуучуудын U19 УАШТ
- 5) Үндэсний цом U16
- 6) Хөвгүүдийн U10, U12 Тэмцээн

4.1.4. 3-р зэрэглэл:

- 1) Сонирхогчдын УАШТ
- 2) Хөвгүүдийн U10, U12 Тэмцээн
- 3) Охидын U11, U13 Тэмцээн
- 4) Фестиваль
- 5) Ахмадын УАШТ
- 6) Бүсийн Лиг
- 7) Бусад тэмцээн

Тав. Бүртгэл, шилжилт хөдөлгөөн

- 5.1. Тоглогчдын бүртгэлийн үйл ажиллагааг МХБХ-ны “Тоглогчдын статус ба шилжилт хөдөлгөөний журам”-аар зохицуулна.
- 5.2. МХБХ-ны “Тоглогчдын шилжилт хөдөлгөөний цонх” нь дараах хугацаанд явагдана. Үүнд:
 - 5.2.1 Солилооны цонх жил бүрийн 11 дугаар сарын 01-ний өдрөөс дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны хооронд явагдаж 01 дүгээр сарын 15-ны өдрийн 17 цаг 00 минутад хаагдана.
 - 5.2.2 Талбайн болон футзалын улирлын дундах шилжилт хөдөлгөөний цонх жил бүрийн 06 дугаар сарын 22-ний өдрөөс 07 дугаар сарын 05-ны хооронд /нийт 14 өдөр/ явагдаж, 07 сарын 05-ны өдрийн 17.00 цагт хаагдана. Хэрэв цонх хаагдах өдөр амралтын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдрийн 17.00 цагт хаагдана.
 - 5.2.3 Тоглогч нь шилжилт хөдөлгөөний цонхоор 1 удаа шилжилт хөдөлгөөн хийнэ.
 - 5.2.4 МХБХ-ны албан ёсны шилжилт хөдөлгөөний цонхоор зөвхөн 16 ба түүнээс дээш насны аль нэг клубт гэрээтэй тоглогчид шилжинэ. Харин 16 нас хүрээгүй тоглогчид шилжилт хөдөлгөөний цонхонд хамааралгүй тэмцээний зааврын дагуу шилжиж болно. Гэхдээ шилжилт хөдөлгөөнд хамааралтай клуб, багуудын хооронд зөвшөөрлийн дагуу зохих бичиг баримтуудыг үйлдсэний дагуу шилжилт хөдөлгөөн хүчинтэйд тооцогдоно.
 - 5.2.5 МХБХ-ны албан ёсны шилжилт хөдөлгөөний цонхоор шилжиж ирэх гадаад тоглогч нь 18 нас хүрсэн байх шаардлагатай ба хэрвээ 18 нас хүрээгүй тоглогчийн шилжилт хийгдэх шаардлагатай тохиолдолд ОУХБХ-ны шилжилт хөдөлгөөний дүрмийн дагуу насанд хүрээгүй тоглогчийг шилжүүлэх журмыг дагаж мөрдөнө.

- 5.3. МХБХ-ны тэмцээн тус бүрт тоглогчдыг шинээр бүртгэх хугацааг тухайн тэмцээний зааварт тусгана. Клуб, баг нь тухайн улиралд бүртгэлийн цонхоор, өөр багт тоглоогүй, гэрээгүй тоглогчийг тэмцээний онцлогоос хамаарч дараагийн шатны бүртгэлд шинээр бүртгүүлж болно. Хэрэв тоглогч өөр клуб, багт харьяалалтай, гэрээтэй бол зөвхөн МХБХ-ны албан ёсны шилжилт хөдөлгөөний цонхоор шилжинэ.
- 5.4. Монгол болон гадаад тоглогчдын шилжилт хөдөлгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зөвхөн FIFA TMS системээр бүртгэж баталгаажуулна.
- 5.3. МХБХ-ны тэмцээний үеэр ТЗБХ-т хандсан аливаа хүсэлт гомдлыг зөвхөн бичгээр хүлээн авна.
- 5.4. МХБХ-ны Дээд болон I-р зэрэглэлийн тэмцээнд оролцох бүх тоглогчид тэмцээний мэдүүлэгт /ТЗБЖ-ын Хавсралт I/ бүртгүүлэхдээ тухайн улирлын шилжилт хөдөлгөөний цонхоор баталгаажсан гэрээтэй байх шаардлагатай. Гэрээ байгуулаагүй болон гэрээний хавсралтгүй тоглогчийг тухайн тэмцээнд оролцуулахгүй болно. Мөн клуб нь тухайн тоглогчийг FIFA Connect системд заавал бүртгүүлсэн байх шаардлагатай.
- 5.5. “Тоглогчийн шилжилт хөдөлгөөний гэрчилгээ” нь тоглогчийн шилжилт хөдөлгөөнийг шилжүүлж байгаа нотолгоо. Нэмэлт мэдээлэл шаардлагатай тохиолдолд клубын албан тоот хавсаргана.
- 5.6. “Тоглогчийн шилжилт хөдөлгөөний гэрчилгээ”-г 16 хүртэл насны тоглогчдын шилжилт хөдөлгөөнд шаардана.
- 5.7. Тэмцээний зааварт тусгасан хугацаанд мэдүүлэг өгөөгүй багийг журмын 2.4 дэх хэсэгт заасны дагуу тухайн тэмцээний бүртгэлээс хасна.
- 5.8. Дараах шаардлагыг хангаагүй мэдүүлгийг тэмцээнд бүртгэхгүй. Үүнд:
- 1) Цээж зураг / сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан/ ;
 - 2) Мэдүүлэг баталгаат гарын үсэггүй ;
 - 3) Хувийн дугааргүй ;
 - 4) Регистрийн дугааргүй ;
 - 5) Овог, нэр дутуу ;
 - 6) Клуб, баг, орон нутгийн холбоо нь өөрийн багийн тоглогчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан албан бичгийг мэдүүлгийн хамт /ТЗБЖ Хавсралт 2/-аар хавсаргаж ирүүлээгүй ;
 - 7) Тэмцээнд оролцох баг үндсэн /эзэн/ ба туслах /зочин/ хувцасны өнгийг мэдүүлгийн хамт /ТЗБЖ-ын Хавсралт 3/-аар хавсаргаж ирүүлээгүй ;
 - 8) Клубын харилцах цахим хаяггүй ;
 - 9) Холбоо барих утасны дугааргүй.
 - 10) Өсвөрийн тэмцээнд оролцох Монгол улсын иргэн заавал гадаад паспорттой байх шаардлагатай. Тус бичиг баримт дээр үндэслэж тухайн тоглогчийг МХБХ-ноос зохион байгуулах тэмцээнд бүртгэнэ.
- 5.9. МХБХ-ны тэмцээнд гадаад болон Монгол тоглогчийг бүртгүүлэхдээ МХБХ-ны “Тоглогчдын статус ба шилжилт хөдөлгөөний журам” болон “FIFA TMS систем”-ийн дагуу материалуудыг бүрдүүлснээр оролцуулах эрхтэй болно.
- 5.10. МХБХ-ны Дээд Лиг, Нэгдүгээр лиг, Хоёрдугаар Лигийн тэмцээнүүдэд мандат ашиглах тул зөвхөн мандаттай тоглогч болон албаны хүн тэмцээнд оролцох эрхтэй. Мандатгүй ирсэн тохиолдолд тоглолтод оролцуулахгүй.
- 5.11. Клуб, баг, орон нутгийн холбоод нь тэмцээний мэдүүлгийг үнэн зөв бөглөж, хариуцлагыг бүрэн хүлээнэ. Клуб, баг нь өөр клубт бүртгэлтэй, гэрээтэй тоглогчийг мэдүүлэгт тусгах, тоглох эрхгүй тоглогчийг тоглолтонд оруулсан тохиолдолд клубт хариуцлага тооцно.

- 5.12. МХБХ-ны 2020 оноос эхлэн тэмцээнд гадаад тоглогчдын тоог тухайн тэмцээний зааварт тусгагдана. (Дээд лиг 3, Нэгдүгээр лиг 2, Хоёрдугаар лиг 1)
- 5.13. МХБХ-ны бүх төрлийн тэмцээнд гадаад тоглогчийг хаалгачаар бүртгүүлэхгүй. /Энэхүү заалт нь 2020 оноос эхлэн хэрэгжинэ/.

Зургаа. Техникийн зөвлөгөөн ба сугалаа

- 6.1. Техникийн зөвлөгөөнийг тэмцээн эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө явуулна. Зөвлөгөөнд клуб, багийн төлөөлөл заавал оролцоно.
- 6.2. Тэмцээний зааврыг тухайн тэмцээн эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө гаргана.
- 6.3. Тэмцээний заавар гарганаас хойш 5 ажлын өдрийн дотор ТЗБХ клуб, багуудаас тэмцээний заавартай холбогдолтой аливаа санал гомдлыг зөвхөн бичгээр хүлээж авна. Техникийн зөвлөгөөний үеэр ямар ч санал гомдол хүлээж авахгүй.
- 6.4. Тэмцээний хураамж төлөөгүй клуб, багийг Техникийн зөвлөгөөн ба сугалаанд оролцуулахгүй. Хураамжийг МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаана. /Энэхүү заалт нь зөвхөн хураамж авахаар заасан тэмцээнүүдэд хамааралтай./
- 6.5. Техникийн зөвлөгөөн дээр ТЗБХ багуудын мэдүүлгийг үндэслэн клуб, багуудын тоглолтын хувцасны өнгийг тодорхойлно. Хасагдах шатны тоглолтуудын хувцасны өнгийг тухай бүрт шийдвэрлэнэ.
- 6.6. Хүндэтгэн үзэх шалтгаанаар тоглолтын хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд 24 цагаас доошгүй хугацаанд тэмцээнд оролцож байгаа бүх багуудад мэдэгдсэн байна.
- 6.7. Дээд ба 1-р зэрэглэлийн тэмцээнд оролцох багууд багийн менежер, дасгалжуулагч нарын уулзалтад өөрийн багийн 2 ээлжийн тоглогч болон хаалгачийн хувцсаа авчирна.

Долоо. Тоглолтын хувцас, хэрэглэл

- 7.1. МХБХ-ны тэмцээнд оролцох клуб, багууд МХБХ-ны “Тоглолтын хувцас, хэрэглэлийн стандартын журам”-ыг баримтлах үүрэгтэй.
- 7.2. Футзалын тэмцээнд оролцох тоглогчид журмын шаардлага хангасан өнгө, будаг гаргадаггүй заалны зориулалтын пүүзтэй байна.
- 7.3. Багийн мэдүүлэгт “0” дугаартай тамирчин мэдүүлэхгүй бөгөөд тамирчин тухайн тэмцээний бүх тоглолтод оролцохдоо зөвхөн мэдүүлэгт бичигдсэн хувийн дугаартай хувцас өмсөнө. Зөрчил гарсан тоглогчийг тоглолтод оролцуулахгүй.
- 7.4. МХБХ-ны тэмцээнд оролцох клуб, багууд МХБХ-ны “Тоглолтын хувцас, хэрэглэлийн стандартын журам”-ыг баримтлаагүй зөрчил гаргасан тохиолдолд МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”-ийн дагуу арга хэмжээ авна.

Найм. Дүн гаргалт

- 8.1. МХБХ-ны тэмцээнд хэсгийн тоглолтын болон хасагдах шатны дүнг энэ зүйлд заасан аргачлал, дарааллын дагуу тооцон гаргана.
- 8.2. Хоёр ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна. Үүнд:
- 1) Хоорондын тоглолтын дүнгээр ;
 - 2) Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр ;
 - 3) Хоорондын тоглолтын оруулсан бөмбөгний ихээр ;
 - 4) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр ;
 - 5) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр ;
 - 6) Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор ;
 - 7) Шодолтоор.
- 8.3. Тэгш тооны багуудтай хэсгүүдээс хамгийн сайн үзүүлэлттэй багийг шалгаруулахад хэсэг бүрийн хүснэгтийн 2-т байх сайн үзүүлэлттэй багуудыг дараах байдлаар тодруулна. /Хүснэгтийн 2-т байгаа багийг жишээ болгов/. Үүнд:
- 1) Хэсгийн бүх тоглолтоос олсон оноогоор ;
 - 2) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр ;
 - 3) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр ;
 - 4) FIFA Fair Play оноо тодруулах зарчмаар ;
 - 5) Шодолтоор.

Тайлбар:

А Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
А баг	3	1	1	1	8	4	4	4
В баг	3	1	1	1	4	3	1	4
С баг	3	1	0	0	7	9	-2	3
Д баг	3	0	0	0	5	8	-3	0

Б Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
Е баг	3	2	1	0	14	2	12	7
Ү баг	3	1	1	1	8	10	-2	4
Г баг	3	0	1	2	5	8	-3	1
Н баг	3	0	1	3	2	9	-7	1

Дээрх хүснэгтийн дагуу **В** болон **Ү** багууд хүснэгтүүдийн 2-т бичигдэж байна.

В болон **Ү** багууд нь тус бүр 4 оноотой. Иймд (1) заалтаар бол 2 баг ижил 4 оноотой тул (2) заалтын /хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр/ дагуу **В баг** +1 гоолын зөрөөтэй бол **Ү баг** -2 гоолын зөрөөтэй тул **В баг** хамгийн сайн үзүүлэлттэй 2-т бичигдэх багаар тодорно.

8.4. Тэгш бус тооны багуудтай хэсгүүдээс хамгийн сайн үзүүлэлттэй багийг дараах байдлаар шалгаруулна. /Хүснэгтийн 2-т байгаа багийг жишээ болгов/. Хэсгүүдэд тэгш бус тооны багууд орсон тохиолдолд тоглолтын тоо тэгш бус байна. Иймд хамгийн сайн үзүүлэлттэй багийг тодруулахын тулд багууд ижил тооны тоглолт хийсэн байх шаардлагатай болдог.

Дээрх тохиолдолд илүү багтай хэсгийн хамааралтай баг болон сүүлийн багийн тоглолтыг тэглэнэ.

Хэсэг бүрийн 2-т байх сайн үзүүлэлттэй багуудыг дараах байдлаар тодруулна. Үүнд:

- 1) Хэсгийн бүх тоглолтоос олсон оноогоор ;
- 2) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр ;
- 3) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр ;
- 4) FIFA Fair Play оноо тодруулах зарчмаар ;
- 5) Шодолтоор.

Тайлбар:

А Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
А баг	3	1	1	1	8	4	4	4
В баг	3	1	1	1	4	3	1	4
С баг	3	1	0	0	7	9	-2	3
Д баг	3	0	0	0	5	8	-3	0

Б Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
Е баг	4	2	1	0	14	2	12	10
Ү баг	4	1	1	1	8	10	-2	7
Г баг	4	0	1	2	5	8	-3	4
Н баг	4	0	1	3	2	9	-7	1
И баг	4	0	0	4	2	11	-9	0

Дээрх хүснэгтийн дагуу **В** болон **Ү** багууд хүснэгтүүдийн 2-т бичигдэж байна.

Хамгийн сайн үзүүлэлттэй багийг тодруулахын тулд хэсгийн багуудын тоог тэнцүүлж тус бүр 4 багтай болгоно.

Иймд Б хэсгийн **Ү** болон **И** багуудын тоглолтыг тэглэнэ. Жишээ нь **Ү** баг **И** багийг 3:0 харьцаатайгаар хожсон.

Иймд 2 хэсгийн тэнцүүлсэн хүснэгтээр дараах байдлаар В болон Ү багууд хүснэгтэнд бичигдэнэ.

А Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
А баг	3	1	1	1	8	4	4	4
В баг	3	1	1	1	4	3	1	4
С баг	3	1	0	0	7	9	-2	3
Д баг	3	0	0	0	5	8	-3	0

Б Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
Е баг	4	2	1	0	14	2	12	10
Ү баг	3	1	1	1	5	10	-2	4
Г баг	4	0	1	2	5	8	-3	4
Н баг	4	0	1	3	2	9	-7	1
І баг	0	0	0	0	0	0	0	0

8.5. Дээд зэрэглэлийн тэмцээний хасагдах шатны тоглолтын дүн тэнцсэн тохиолдолд:

1 тоглолттой үед:

- 1) Нэмэлт цаг :
- 2) 11 м-ийн торгуулийн цохилтоор шийдвэрлэнэ.

2 тоглолттой үед:

- 3) Бөмбөгний харьцаа :
- 4) Зочин баг олон гоол оруулснаар :
- 5) Нэмэлт цаг:
- 6) 11 м-ийн торгуулийн цохилтоор шийдвэрлэнэ.

8.6. Тэмцээний хасагдах шатны ижил даваанд хожигдсон багуудын чансааг дараах байдлаар тодруулна.

- 1) Тэмцээний турш хийсэн бүх тоглолтын оноогоор /ОУХБХ-ны хүлээн зөвшөөрдөг Статистикийн конвенцид хэсгийн болон хасагдах шатны ялгаагүй аль ч тоглолтын хожлыг 3, тэнцээг 1, хожигдлыг 0 оноогоор тооцно. Хасагдах шатны тоглолтын нэмэлт цаг буюу Extra time-д хожсон багийг хожсон, хожигдсон багийг хожигдсон, тэнцсэн хоёр багийг торгуулийн цохилтын үр дүнгээс үл хамааран тэнцсэн хэмээн үзэж, зохих оноог өгч тооцдог. As per statistical convention in football, matches decided in extra time are counted as wins and losses, while matches decided by penalty shoot-outs are counted as draws. Source: FIFA/ :
- 2) Бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр :
- 3) Бүх тоглолтод оруулсан бөмбөгний ихээр :
- 4) Шодолтоор.

А Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
А баг	3	1	1	1	8	4	4	4
В баг	3	1	1	1	4	3	1	4
С баг	3	1	0	2	7	9	-2	3
Д баг	3	0	0	3	5	8	-3	0

Б Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
Е баг	3	2	1	0	14	2	12	7
Ү баг	3	1	1	1	8	10	-2	4
Г баг	3	0	1	2	5	8	-3	1
Н баг	3	0	1	2	2	9	-7	1

В Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
I баг	3	1	2	0	6	3	3	5
J баг	3	1	2	0	4	3	1	5
K баг	3	1	2	0	3	2	1	5
L баг	3	0	0	3	1	6	-5	0

Г Хэсэг

Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
M баг	3	2	1	0	10	3	7	7
N баг	3	2	1	0	8	5	3	7
O баг	3	1	0	2	3	6	-3	3
P баг	3	0	0	3	1	8	-7	0

1/4 шигшээ тоглолт:

A баг - F баг 3:0

I баг - N баг 1:0

E баг - B баг 2:1 (нэмэлт цаг)

M баг - J баг 0:0, 5:4 (торгуулын цохилт)

1/4 шигшээ тоглолтод хожигдсон багуудын тэмцээний нэгдсэн дүнд эзлэх чансаа

Байр	Баг	Тоглолт	Хожил	Тэнцүү	Хожигдол	ОБ	АБ	БЗ	Оноо
5	N баг	4	2	1	1	8	6	2	8
6	J баг	4	1	3	0	4	3	1	6
7	B баг	4	1	1	2	5	5	0	4
8	F баг	4	1	1	2	8	13	-5	4

8.7. Хэрэв тэмцээний хэсгийн тоглолт тэгш бус тооны багуудтай байсан бол хасагдах шатны ижил даваанд хожигдсон багуудын чансааг тодруулахдаа илүү багтай хэсгийн сүүлийн багийн тоглолтыг тэглэж, үргэлжлүүлэн журмын 8.4 дэх хэсэгт заасныг баримтална.

Ес. Хугацаа

9.1. Тоглолтын хугацааг дараах байдлаар тогтооно. Үүнд:

Төрөл	Дээд зэрэглэл	Хугацаа	14 наснаас дээш	Хугацаа	14 наснаас доош	Хугацаа
Талбай	ОУХБХ-ны дүрмээр	ОУХБХ-ны дүрмээр	40 – 45	Техникийн хэлтэс шийдвэрлэнэ	ТЗБХ шийдвэрлэнэ	Нэмэлт цаггүй
Футзал	ОУХБХ-ны дүрмээр	Цэвэр цаг	15-20	Цэвэр цаг	ТЗБХ шийдвэрлэнэ	Цэвэр цаг

- 9.2. Клуб ба багууд Дээд болон I-р зэрэглэлийн тэмцээний тоглолт эхлэхээс хамгийн багадаа 90 минут өмнө ирсэн байх шаардлагатай.
- 9.3. Тэмцээний зааварт өөрөөр тусгаагүй бол лигийн тоглолт эхлэхээс 80 минутын өмнө тоглолтын протокол гарсан байх шаардлагатай. Хэрэв дээрх хугацаанд багийн албаны хүн нь тоглолтын протоколыг бөглөөгүй тохиолдолд тухайн багийг МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”-ийн дагуу арга хэмжээ авна.

Арав. Тэмцээний үед мөрдөх журам

- 10.1. Тэмцээнд оролцож буй нийт баг тоглогчид, хөлбөмбөгийн спортыг эвсэг, нөхөрсөг, шударга, сонирхолтой байлгахын төлөө FIFA-гаас боловсруулан гаргасан “FAIR PLAY” зарчмыг тэмцээний турш мөрдөх үүрэгтэй.
- 10.2. Тоглолт наймаалцах, тэмцээний явцад ямар нэгэн байдлаар өөрийн багтаа ашигтайгаар нөлөөлөх үйлдэл хийх, бусад багуудын эрх ашигт ноцтойгоор халдаж тэмцээний зохион байгуулалтанд хүндрэл учруулсан нь нотлогдвол МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”, “Ёс зүйн хорооны дүрэм”-ийн дагуу тус тус хариуцлага хүлээлгэнэ.
- 10.3. Талбайн болон футзалын тэмцээнд клуб, багийг төлөөлж 1 баг оролцоно. Зөвхөн U10 болон U12 насны тэмцээнүүдэд 1 клубээс 2 баг орохын зөвшөөрнө.
- 10.4. Тухайн тэмцээний зааварт өөрөөр тусгаагүй бол Дээд лиг, Нэгдүгээр лиг, Хоёрдугаар лиг мөн аливаа насанд хүрэгчдийн тэмцээнд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 17 насанд хүрээгүй тоглогч тоглохыг зөвшөөрөхгүй.
- 10.5. Тоглогч нь футзалын болон талбайн улирлын туршид зөвхөн 1 багийг төлөөлөн тоглоно. МХБХ-ны албан ёсны шилжилт хөдөлгөөний цонхоор шилжилт хөдөлгөөн хийхийг зөвшөөрнө.
/Бусад тохиолдолд тэмцээний онцлогоос хамаарч зөвхөн өөрийн клуб, багт бүртгэлтэй эсвэл гэрээтэй тоглогчдыг шинэчилсэн бүртгэлээр сольж болно./
- 10.6. МХБХ-ны тэмцээнүүдэд оролцох багийн тоо 6 хүрэхгүй бол тухайн тэмцээнийг зохион явуулах эсэхийг ТЗБХ шийдвэрлэнэ.
- 10.7. Тэмцээний зааварт өөрөөр тусгаагүй тохиолдолд талбайн тэмцээнд оролцох багийн мэдүүлэгт бүртгүүлэх тоглогчдын тоо **15-30** харин футзалын тэмцээнд оролцох багийн мэдүүлэгт бүртгүүлэх тоглогчдын тоо **10-16** байна.

- 10.8. Тэмцээний медалийн тоог тухайн тэмцээний зааварт тусгана.
- 10.9. Лигийн медалийг зөвхөн лигийн зааварт тусгасан тоогоор багт олгоно. Лигийн тэмцээнд хамгийн багадаа 3 тоглолтод талбайд гарсан тохиолдолд тоглогч медаль авах эрхтэй. /Тус заалт хаалгач нарт хамаарахгүй болно./
- 10.10. Лигийн тэмцээнд оролцох багийн тоглогчдын тоог тухайн тэмцээний зааварт тусгана.
- 10.11. Тэмцээний нээлт, хаалт, шагналын үйл ажиллагаа болон тухайн тэмцээний зохион байгуулалттай арга хэмжээнүүдэд аль нэг баг оролцоогүй эсвэл бүрэн бус бүрэлдэхүүнтэй оролцсон бол тухайн багт сахилгын арга хэмжээ ноогдуулна.
- 10.12. Тэмцээний зааварт заасан тохиолдолд тэмцээнд оролцогч багийн дасгалжуулагч, багийн ахлагч болон түлхүүр тоглогч тоглолтын өмнө болон дараа хэвлэл мэдээллийнхэнд ярилцлага өгөх үүрэгтэй.
- 10.13. Тоглолт эхлэхийн өмнө өрсөлдөгч хоёр баг “Fair Play” зарчмыг баримтлан тоглохоо илэрхийлж гар барих ёслолыг заавал үйлддэгтэй нэгэн адил тоглолт дуусмагц тоглолтын үр дүнгээс үл хамааран хоёр багийн тоглогчид шүүгч нартай болон өөр хоорондоо гар барих үүрэгтэй. Тухайн тоглолтын эхлэл, төгсгөлд хөгжөөн дэмжигчдэд хүндэтгэл үзүүлнэ. Тоглолтын дараа гар барих ёслол үйлдээгүй тохиолдолд МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”-ийн дагуу арга хэмжээ авна.
- 10.14. Дээд болон 1 дүгээр зэрэглэлийн тэмцээнд тоглогчдын хувцас солих өрөөнд багийн мэдүүлэгт бичигдээгүй хүн орохыг хориглоно. Хэрэв энэ заалтыг зөрчсөн тохиолдолд тухайн багт МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”-ийн дагуу арга хэмжээ авна.
- 10.15. Тоглогч болон албаны хүн МХБХ-ны тэмцээнд хуудасны болон сахилгын торгууль авсан тохиолдолд хугацаа харгалзахгүй бүх төрлийн тэмцээнд хүчинтэй тооцогдоно.
- 10.16. МХБХ-ны лиг болон бусад тэмцээнд оролцох эрхтэй клуб нь аливаа шалтгаанаар лиг болон бусад тэмцээнд оролцоогүй тохиолдолд, тус клубыг тухайн жилийн тэмцээнүүдэд оролцох эрхийг хасна. Харин дараагийн жилээс эхлэн хамгийн доод төвшний тэмцээнд оролцож болно. МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу нэмэлт арга хэмжээ авч болно.

Арван нэг. Шагнал урамшуулал, эрхийн хураамж

- 11.1. МХБХ-ны 10 болон 12 хүртэл насны тэмцээнээс бусад бүх тэмцээн бүрт шилдэг багуудыг шалгаруулж, багт өргөмжлөл, тоглогчдод батламж, медаль олгоно. Цомтой тэмцээнд цом олгоно. Тэмцээнд оролцож байгаа багийн тоо 6 хүрээгүй тохиолдолд хэдэн баг шагнахыг ТЗБХ шийдвэрлэнэ.
- 11.2. МХБХ-ны урьдчилсан шатны тэмцээнтэй тохиолдолд тухайн хэсгээс шалгарч шигшээ шатанд оролцох эрх авсан багуудад тэмцээний зааварт тусгасан мөнгөн шагналаар урамшуулна.
- 11.3. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу нийт шагналын сангийн 5 хувийг суутган тооцож, Татварын байгууллагад шилжүүлнэ.
- 11.4. МХБХ-ны Цом, Супер Цом болон Ахмадын УАШТ-ээс бусад тэмцээнүүдэд шилдгүүдийг шалгаруулна.
- 11.5. Ахмадын Футзалын УАШТ-д оролцсон 60 наснаас дээш настангуудад хүндэтгэл үзүүлнэ.
- 11.6. Тэмцээний зааварт шагнал урамшууллын мөнгөн дүнг заавал тусгана.
- 11.7. МХБХ-ны Зөвлөлийн баталсан тогтоолын эрхийн хураамжыг тухайн тэмцээний зааварт тусгана.

Арван хоёр. Багийн менежер, дасгалжуулагч, багийн ахлагч, эмчийн эрх, үүрэг

- 12.1. Багийн менежер, ахлах болон туслах дасгалжуулагч, багийн ахлагч, эмч нар нь хариуцсан чиглэлээ төлөөлөх бүрэн чадвартай байж эрх, үүргээ ухамсарласан байна.
- 12.2. Багийн менежер нь тухайн багийг хариуцсан эрх бүхий албан тушаалтан байна.
- 12.3. МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь тоглолтын шүүгчийн шийдвэртэй холбоотой аливаа эсэргүүцлийг сонин хэвлэл, телевиз болон цахим орчин ашиглаж олон нийтэд цацахыг хориглох ба зөрчсөн тохиолдолд МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу арга хэмжээ авна.
- 12.4. Тэмцээнд оролцох дасгалжуулагч нь зөвхөн МХБХ-ны Техникийн хэлтсээс олгосон “Дасгалжуулагчийн лиценз”-тэй байж тоглолтонд оролцоно. МХБХ-ны бүх тэмцээнд лицензтэй дасгалжуулагч байхгүй тохиолдолд тоглолт эхлэхгүй. Тоглолтыг цуцлаж эсрэг багт 3-0 хожил олгоно.
- 12.5. АХБХ болон МХБХ-ноос олгосон “Дасгалжуулагчийн гэрчилгээ” нь тухайн дасгалжуулагчийг тоглолтод дасгалжуулах эрх олгохгүй.
- 12.6. Дээд лиг болон Нэгдүгээр лигүүд дээр заавал ахлах болон туслах дасгалжуулагч байна. Хүндэтгэх шалтгааныг харгалзан үзнэ. Харин бусад тэмцээнүүд дээр ахлах юм уу туслах дасгалжуулагчийн аль нэг нь байж болно.
- 12.7. Дээд лигийн тоглолтонд ахлах дасгалжуулагч эсвэл туслах дасгалжуулагчгүй оролцсон тохиолдолд тухайн багийг 200,000 төгрөгөөр торгоно. Тус торгуулийг тэмцээний дараагийн тоглолтын өмнө заавал төлсөн байх шаардлагатай. Төлөөгүй тохиолдолд тухайн багийн дараагийн тоглолт явагдахгүй. Хэрэв тус баг нь хоёрдох удаа дээрх зөрчил гаргасан тохиолдолд 400,000 төгрөг харин гуравдах удаа давтан үйлдсэн тохиолдолд 600,000 төгрөг болон -3 оноогоор шийтгэнэ. Нэгдүгээр лигийн тоглолтонд ахлах дасгалжуулагч эсвэл туслах дасгалжуулагчгүй оролцсон тохиолдолд тухайн багийг 100,000 төгрөгөөр торгоно. Тус торгуулийг тэмцээний дараагийн тоглолтын өмнө заавал төлсөн байх шаардлагатай. Төлөөгүй тохиолдолд тухайн багийг дараагийн тоглолт явагдахгүй. Хэрэв тус баг нь хоёрдох удаа дээрх зөрчил гаргасан тохиолдолд 200,000 төгрөг харин гуравдах удаа давтан үйлдсэн тохиолдолд 300,000 төгрөг болон -3 оноогоор шийтгэнэ. Аль нэг дасгалжуулагч тоглолтонд оролцох боломжгүй тохиолдолд тухайн клуб нь заавал тоглолтын 1 өдрийн өмнө МХБХ-ны Техникийн хэлтэст албан бичгээр тайлбар явуулах шаардлагатай. Техникийн хэлтэс тус тайлбар нь үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн дасгалжуулагчийг чөлөөлнө. Харин түүний оронд тус клуб нь хүүхдийн багаасаа лицензтэй туслах дасгалжуулагч ажилуулна.
- 12.8. Лигийн тоглолтод багийн албаны хүн шүүгчийн шийдвэрээр техникийн бүсээс чөлөөлөгдсөн тохиолдолд тоглолтын дараах хэвлэлийн бага хурал болон бусад албан ёсны арга хэмжээнд оролцохыг хориглоно. Хэрэв тоглолтын 1-р үед дээрх шийдвэр гарсан бол тоглолтын завсарлагаанаар тухайн албаны хүн хувцас солих өрөөнд орохыг хориглоно. Зөрчсөн тохиолдолд тухайн албаны хүн дахин 1 тоглолт өнжинө.
- 12.9. Техникийн бүсээс чөлөөлөгдсөний дараа дасгалжуулагч нь тусгайлан бэлдсэн суудлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд тухайн албаны хүнийг МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”-ийн дагуу торгоно.
- 12.10. МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь үзэгчдийн суудлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”-ийн дагуу торгоно.
- 12.11. Хэрэв тоглолтын явцад аливаа шалтгаанаар дасгалжуулагчгүй (багийн менежер, эмчид хамаарахгүй) болсон тохиолдолд тухайн баг нь сэлгээ хийх эрхгүй тоглолтыг дуусгана.

- 12.12. Дасгалжуулагч нь клубтэй хийсэн гэрээгээ ТЗБХ-т заавал бүртгүүлнэ.
- 12.13. Дасгалжуулагч нь МХБХ-ны тэмцээнд хамгийн ихдээ зөвхөн 2 дараалсан насанд (жишээ нь U10, U12 болон U12, U14 насанд г.м) дасгалжуулах эрхтэй. /Энэхүү заалт нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.
- 12.14. МХБХ-ноос 2019 онд зохион байгуулдаг тэмцээний ангиллаас хамаарч оролцож байгаа клуб, багуудад заавал тухайн тэмцээний зааварт тусгасан “Дасгалжуулагчийн зэрэглэл” болон “Дасгалжуулагчийн лиценз”-ийг биелүүлсэн байхыг шаардана.

Д/д	Ажиллах баг	Ахлах дасгалжуулагч	Туслах дасгалжуулагч
1	Үндэсний Дээд Лиг	AFC “A” ба түүнээс дээш /2020 оны 01 дүгээр сарын 01-нээс /	AFC “C” ба түүнээс дээш
2	Үндэсний I-р Лиг	AFC “B” ба түүнээс дээш /2020 оны 01 дүгээр сарын 01-нээс /	AFC “C” ба түүнээс дээш
3	УАШТ	AFC “C” ба түүнээс дээш	MFF “D” ба түүнээс дээш
4	Эмэгтэйчүүдийн Лиг	AFC “B” ба түүнээс дээш	AFC “C” ба түүнээс дээш
5	Өсвөр ба Идэрчүүд	AFC “C” ба түүнээс дээш	MFF “D” ба түүнээс дээш
6	Футзалын Дээд Лиг	“Level 2” ба түүнээс дээш	“Level 1” ба түүнээс дээш
7	Футзалын бусад тэмцээн	“Level 1” ба түүнээс дээш	MFF “D” ба түүнээс дээш

- 12.15. Багийн ахлагч нар тоглолтын үед хөлбөмбөгийн “Fair Play” зарчмыг мөрдүүлэхийн төлөө өөрийн багийн тамирчдын ёс зүй, сахилга батын асуудалд үлгэр жишээ үзүүлж, багийн манлайлагчийн үүргийг гүйцэтгэнэ.
- 12.16. Багийн ахлагч нь өөрийн багийг тоглолтын өмнө болон дараа эсрэг баг, хөгжөөн дэмжигчдэд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг удирдан явуулна.
- 12.17. Тоглолт дууссаны дараа өрсөлдөгч багийн дасгалжуулагч болон албаны хүмүүст хүндэтгэл үзүүлнэ.

Арван гурав. Тэмцээний сахилга бат, ёс зүй

- 13.1. МХБХ-ны бүх тэмцээний үед гарсан сахилга бат, ёс зүйн холбогдолтой асуудлуудыг МХБХ-ны “Сахилгын хорооны дүрэм”, “Ёс зүйн хорооны дүрэм”-ээр шийдвэрлэнэ.

Арван дөрөв. Эмч

- 14.1. МХБХ-ны Дээд болон Нэгдүгээр лигийн багууд тоглолтод оролцоходоо өөрийн эмчтэй оролцоно. Эмчгүй тохиолдолд тухайн зөрчил гаргасан багийг 300,000 төгрөгөөр торгоно. Бусад тэмцээнүүдэд ажиллах эмчийн шаардлагыг тухайн тэмцээний зааварт тусгана.

Арван тав. Аюулгүй байдал, харуул хамгаалалт

- 15.1. МХБХ-ны Дээд лиг, Нэгдүгээр лиг болон Ахмадын УАШТ-үүдэд хамгаалалт ажилдуулна. Гэрээт хамгаалалтын алба нь МХБХ-ны ТЗБХ-ийн удирдлага дор ажиллана.
- 15.2. МХБХ нь өөрийн сайн дурын хамгаалалтын ажилчдыг ажиллуулах эрхтэй.

Арван зургаа. Хэвлэл мэдээлэл, маркетинг

- 16.1. Тэмцээний үеэр ажиллах хэвлэл мэдээллийн хүмүүсийг албан ёсны зөвшөөрөлтэйгээр тусгайлан зааж өгсөн газар ажиллахыг зөвшөөрнө.
- 16.2. Хэвлэл мэдээллийн хүмүүст тэмцээний мандат болон майктай байхыг шаардана.

Арван долоо. Тэмцээн зохион байгуулах комисс

- 17.1. Тэмцээнийг МХБХ-ны ТЗБХ-ээс томилогдсон Тэмцээн зохион байгуулах комисс /ТЗБК/ удирдан, Олон Улсын хөлбөмбөгийн холбоо /FIFA/, Азийн хөлбөмбөгийн холбоо /AFC/, Монголын хөлбөмбөгийн холбоо /МХБХ/-ны дүрэм, журам, заавар болон бусад эрх зүйн баримт бичгүүдийн дагуу зохион байгуулна.
- 17.2. Тэмцээн зохион байгуулах комисс дараах гишүүдтэй байна. Үүнд:
- 1) ТЗБК-ын дарга
 - 2) Дэд дарга
 - 3) Техникийн хэлтсийн төлөөлөл – 2
 - 4) Шүүгчийн хэлтсийн төлөөлөл
 - 5) Эмчийн төлөөлөл
 - 6) Аюулгүй байдлын төлөөлөл
 - 7) Маркетинг, хэвлэл мэдээлэл
 - 8) Ивээн тэтгэгч
- 17.3. ТЗБК-оос гаргасан шийдвэрийг комиссын дарга баталгаажуулж ТЗБХ-ийн захиралд танилцуулна.

Арван найм. Бусад

- 18.1. МХБХ-ны ТЗБХ бүрэн эрхэд хамаарахгүй асуудлыг МХБХ-ны холбогдох хороодод шилжүүлнэ.
- 18.2. Энэхүү журамд дараах хавсралтууд багтсан болно. Үүнд:
- | | |
|--------------------|-----------------------|
| 1) ТЗБЖ Хавсралт 1 | Тэмцээний мэдүүлэг : |
| 2) ТЗБЖ Хавсралт 2 | Эрүүл мэндийн хуудас: |
| 3) ТЗБЖ Хавсралт 3 | Хувцасны өнгө. |
- 18.3. Тус журмыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

